



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2024.07.31

№ 720

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ҮНЭН БА ЗӨВ НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Үнэн ба зөв намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын

232420743

хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Үнэн ба зөв намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Үнэн ба зөв намын мөрийн хөтөлбөр (5 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн сонгуулийн хороонд.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:  
АУДИТОР



Т.АЛТАНШАГАЙ

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД



**ҮНЭН БА ЗӨВ НАМ**

# **ХҮЧТЭЙ СӨРӨГ ХҮЧИН**

**ҮНЭН БА ЗӨВ НАМ-ын  
Хэнтий аймгийн ИТХ-ын  
сонгуулийн мөрийн хөтөлбөр**

## ТӨРД ХЯНАЛТ ТҮМЭНД ИТГЭЛ...

### ТОВЧЛОЛ

Монгол Улсын өнгөрсөн 30 жилийн нийгэм, улс төрийн бодлого, амьдралд дүгнэлт хийж, 1990-2020 оныг хүртэлх УИХ 8 удаагийн, Ерөнхийлөгчийн 9 удаагийн, Орон нутгийн 8 удаагийн сонгуулиар ард түмэн, сонгогчдын сонголт, итгэл найдварыг зөвхөн өөрсдийн ЯЛАЛТ хэмээн ойлгож, МАНАН шударга ёсыг уландаа гишгэж, хууль гаргаж хулгай хийдэг авлигажсан, өрөнд орсон, ард түмэн нь ядуу өнөөгийн Монгол Улсыг бий болгосон байна.

Бид шударга ухаант ард түмний МАН, АН намуудын төр барих хугацааны үнэлэлт, дүгнэлт байнгын шүүмжлэлүүдтэй санал нэгдсэний үндсэн дээр 2017 онд Монгол Улсаа мандуулах гарц болгож Улс Төрийн жинхэнэ хүчин ҮНЭН БА ЗӨВ намыг байгуулсан болно.

МАНАН-г устгах нь чухал боловч МАНАН-ыг устгасны дараа Монгол Улсаа хүчирхэг болгож, ард түмнээ амар амгалан амьдруулах нь түүнээс чухал тул бид МОНГОЛ УЛСЫНХАА гурван цагийн хэлхээнд дүгнэлт хийж ард түмний хүлээлт, шаардлагад нийцсэн Улсаа засаж, хөгжүүлэх, үндсэн чиглэлийг дараах 5 бүлэгт багтаан гүйцэтгэхээр төлөвлөж буйгаа санал болгож байна. Бид хүчтэй улс төрийн хүчин байж төрд хяналт тогтоохоос гадна зөв зүйлийг дэмжиж хамтран ажиллах болно. Улс орон минь хөгжиж, ард түмэн жаргалтай амьдрах болтугай.

2317144297  
СЮА0046 9074782

## ҮНЭН БА ЗӨВ НАМ УЛСАА ЗАСАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
  - хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
  - төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
  - хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго дор сайн чигийг зөв заах ҮНЭН БА ЗӨВ НАМ-ын Хэнтий аймгийн ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ

**НЭГЭН ЗҮЙЛ:** Монголын ард түмний төлөө МАН, АН-ын хэзээ ч хийхгүй зүйлийг Монголын ард түмнийхээ төлөө ҮНЭН БА ЗӨВ НАМ дараах заалтуудаар хийнэ.

- 1.1 Монгол судлалыг хөгжүүлэхийг дэмжиж, дотоод, гадаадын судлаач, эрдэмтдийн судалгаа, аялал жуулчлалын шинжтэй аймгийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд жил тутам зохион байгуулан, цаашид уламжлал болгоно.
- 1.2 Монголчуудын эв нэгдэл, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх ажлыг төр засгийн нэн тэргүүний ажил гэж үзнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ БАДРАН ГИЙХ МОНГОЛ ХҮН

- 2.1 Ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлыг арилгах зорилгоор боловсролын хүртээмжийг сайжруулж, аз жаргалтай Монгол хүнийг бий болно.
- 2.2 Боловсрол /Мэдлэг + Чадвар + Хүмүүжил + Ёс зүй + Хариуцлага + Өв соёл+.../ ын ойлголтыг зөв тодорхойлж улс орноо хүчирхэг болгох зөв сэтгэлтэй иргэдийг бэлдэнэ.
- 2.3 Хүүхэд, өсвөр үеийнхнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, амьдрах ухаанд сургахад чиглэгдсэн ном зохиол, бүтээл туурвилыг төрөөс хөхүүлэн дэмжинэ.
- 2.4 Сургууль бүрд төрөл бүрийн клуб, дугуйлан хичээллүүлж, хүүхэд бүр 2-оос дээш дугуйлан, клубт хамрагдана.
- 2.5 Нэг хүүхдийн асуудлыг – Нэгдсэн сургалт"-ын хөтөлбөрт тусгах ажлыг санаачилж, хүүхэд бүрийн өөрийн оролцоонд тулгуурласан сургалтын орчин бүрдүүлнэ.
- 2.6 Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт заавал хамруулна. Монгол хүний дундаж наслалтыг 75 насанд хүргэх эрүүл, аюулгүй, аз жаргалтай нийгмийг бүтээнэ.
- 2.7 Шинжлэх ухаанд суурилсан, шинжлэх ухааны бүтээлийг олон улсад таниулж, иргэн төвтэй үнэ цэнийг бий болгоно.

- 2.8 Монгол анагаах ухааныг дэлхийн брэнд болгож, анагаах ухааны мэдлэг, судалгааны ажил, уламжлалт эмийг экспортолно.
- 2.9 Өндөр технологи, нано-технологи, инновацын бүтээлийг бодлогоор дэмжинэ.
- 2.10 Аймгийн иргэд аймаг, орон нутагтаа ажиллаж хөдөлмөрлөх таатай орчин бий болгоно.
- 2.11 Эмэгтэйчүүдийг хүчирхэг, эдийн засаг, санхүүгийн хараат бус, аз жаргалтай амьдрах бүх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.12 Залуучуудыг гадны өндөр хөгжилтэй улсад сурч, ажиллах нөхцөл боломжоор хангах ажлыг зохион байгуулна.

### ГУРАВДУГААР БҮЛЭГ АЧЛАЛТ ТӨР - ЗАСАГЛАЛ

- 3.1 Иргэдийн эх орноо хөгжүүлэх, ажил хэрэгч саналыг дэмжиж ажиллана.
- 3.2 Иргэн та асуудал дэвшүүлж, хүсэлтээ бидэнд гаргах юм бол бид тэр санал хүсэлтийг шийдвэрлэх хүртэл нэхэж ажилладаг хариуцлагатай улстөрийн хүчин байна.
- 3.3 Чадварлаг боловсон хүчин төрийн албан хаагчдын ажлын байрыг баталгаажуулна.
- 3.4 Төрийн албыг цомхон, чадварлаг, хариуцлагатай, ёс зүйтэй ажилладаг болгон шинэчилнэ. Төрийн албан хаагч улс төрийн нөлөөллөөс болж ажлаас халдаг байдлыг бүрэн зогсооно.
- 3.5 Төрийн албан хаагчдыг шилж сонгох, мэргэжил ур чадварыг нь дээшлүүлэх, идэвхжүүлэх тогтолцоог төгөлдөржүүлнэ.
- 3.6 Монголын төрөөс хулгай хийсэн, авлига авсан, гадны эрх ашигт үйлчилсэн хүнийг 3 үеэр нь Монголын төрд ажиллуулахгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор хуулийн төсөл өргөн барина.
- 3.7 Байгалийн баялаг, иргэдийн боломжийг дээрэмдэж хөрөнгөжсөн хүмүүст хөрөнгийн эх үүсвэрээ нотлох шалгалт оруулан, зохих шатны хууль хяналтын байгууллагад шилжүүлж ажиллана.
- 3.8 Эрүүл мэндийн салбар дахь эрх мэдэлтнүүдийн нөлөөллийг арилгаж, шударга тогтолцоог бүрдүүлнэ.

### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НЭГЭН ЗҮЙЛ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 4.1 Гол мөрөн, ойн санг хамгаалах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мод тарих, бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх хөтөлбөрийг дэмжинэ.
- 4.2 Гамшигтай тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгон засаг захиргааны нэгж, бүс нутгийн чадварыг сайжруулна.

**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН**  
**БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 5.1 Малчдын талаар төрөөс баримталж буй бодлогын шинэчлэлийг санаачилж, малчдын нийгэм, эрүүл мэндийн баталгааг сайжруулна.
- 5.2 Аймгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааны үр ашгийг дээшлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 6.1 Дэлхий дахины болон бүс нутгийн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд харилцан ашигтай байх зарчмыг баримтлан идэвхтэй оролцоно.

**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ҮНДЭС**

- 7.1 Гадаад орнуудын хамтын ажиллагааг зохих шатанд дэмжиж ажиллахдаа үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого явуулна.

**ҮНЭН ЯЛНА ҮР ҮЛДЭНЭ...**